

Төрийн аудитын байгууллагаас 2019 онд гүйцэтгэсэн “Иргэн, хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр, үйл ажиллагаа нь Газрын тухай хуульд нийцсэн эсэх /2015-2018/” сэдэвт аудитаар Үндэсний аудитын газрын тогтоосон акт, холбогдох байгууллага, албан тушаалтанд өгсөн албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтэд хийх давтан аudit.

АУДИТИН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үндэсний аудитын газар
2020 он

АГУУЛГА

Агуулга	1
Товчилсон үгийн жагсаалт	2
Аудитын нэр	3
Аудитын код	3
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	3
Аудитын зорилт	3
Аудитын хамрах хүрээ	3
Үндсэн мэдээлэл	4
Эрсдэлийн үнэлгээ	5
Аудитын арга зүй	5
Аудит хийхэд ашиглах шалгуур үзүүлэлт:.....	5-7
Аудитыг гүйцэтгэх хугацаа	7
Аудит хийх багийн бүрэлдэхүүн	7
Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц	7
Төлөвлөгөөний баталгаажуулах хэсэг.....	7
Хавсралт №1 Эрсдэлийн үнэлгээ, материаллаг байдал	8-9
Хавсралт №2 Асуудлын шинжилгээ	10
Хавсралт №3 Аудитын арга зүй	11-20
Хавсралт №4 Аудитын үр өгөөжийн төлөвлөлт	21
Хавсралт №5 Аудитын хөтөлбөр	22-23

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БОАЖЯ	Байгаль, орчин, аялал, жуулчлалын яам
БЗД	Баянзүрх дүүрэг
БХБЯ	Барилга, хот, байгуулалтын яам
БЦГ	Байгалийн цогцолбор газар
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар
ДЦГ	Дархан цаазат газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
НА	Нийцлийн аудит
НАГ	Нийцлийн аудитын газар
ХУД	Хан-Уул дүүрэг
ЧБЗ	Чөлөөт бүсийн захиргаа
УИХ	Улсын Их Хурал
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ҮАГ	Үндэсний аудитын газар



1. Аудитын нэр: Төрийн аудитын байгууллагаас 2019 онд гүйцэтгэсэн “Иргэн, хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр, үйл ажиллагаа нь Газрын тухай хуульд нийцсэн эсэх /2015-2018/” сэдэвт аудитаар Үндэсний аудитын газрын тогтоосон акт, холбогдох байгууллага, албан тушаалтанд өгсөн албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтэд хийх давтан аудит.

2. Аудитын код: УАГ-НАГ-2020/06/-ДА.

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтыг үндэслэн УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2019 оны 05 дугаар тогтоо, Үндэсний аудитын газрын 2020 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ.

4. Аудитын зорилт:

Төрийн аудитын байгууллагаас 2019 онд гүйцэтгэсэн “Иргэн, хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр, үйл ажиллагаа нь Газрын тухай хуульд нийцсэн эсэх /2015-2018/” сэдэвт аудитаар Үндэсний аудитын газрын тогтоосон акт, холбогдох байгууллага, албан тушаалтанд өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийн байдалд давтан аудит хийж, аудитын дүнг УИХ-д танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Дээрх зорилтын хүрээнд дараах дэд зорилтын дагуу аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Өмнөх аудитын тайланд тусгасан зөрчлийг арилгах, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллага, албан тушаалтнууд арга хэмжээ авч ажилласан эсэх;
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэх, тогтоосон төлбөрийн актыг барагдуулах талаар холбогдох байгууллага, албан тушаалтнууд арга хэмжээ авч ажилласан эсэх.

5. Аудитын хамрах хүрээ:

Тус аудитад Монгол Улсын Засгийн газар, БОАЖЯ, БХБЯ, УУХҮЯ болон тэдгээрийн харьяа холбогдох байгууллагууд, нийслэлийн болон зарим аймаг, дүүргийн Засаг дарга, газрын харилцааны чиглэлийн бусад байгууллага, албан тушаалтны өмнөх аудитын тайлангаар тогтоосон акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх хугацааны үйл ажиллагааг хамруулж, холбогдох шийдвэр, хувийн хэрэг, баримт материалд үндэслэн шалгана.

6. Үндсэн мэдээлэл:

Үндэсний аудитын газрын 2019 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу 2019 онд улсын хэмжээнд иргэн, хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр, үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн эсэх /2015-2018/-д аудит хийж, тайланг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/105 дугаар тушаалаар баталгаажуулан, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, аудитын дүнг УИХ-д танилцуулан, олон нийтэд мэдээлсэн.

Тус аудитад БОАЖЯ, Замын Үүд ЧБЗ, Алтанбулаг ЧБЗ, Цагаан нур ЧБЗ, ГЗБГЗЗГ болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, ЗДТГ, Газрын алба, Газрын даамал зэрэг газрын харилцааны чиглэлийн байгууллага, албан тушаалтны 2015 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааны газар олголт, ашиглалттай холбогдох үйл ажиллагааг хамруулан, тухайн байгууллага, албан тушаалтны газар эзэмшүүлэх, ашиглуулахтай холбогдох шийдвэр, нэгж талбарын хувийн хэрэг, баримт материалыг түүвэрлэн шалгасан.

Харин МУЕА-н баталсан аудитын төлөвлөгөөний дагуу уг аудитаар Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-16.1.5, 16.1.10, 16.1.11-16.1.14 дэх заалтад хамаарах хилийн зурvas газар, улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалттай газар зэрэг тусгай хэрэгцээний ангиллын газар олголтын асуудал, мөн УИХ, Засгийн газрын шийдвэрээр зарим газрыг улсын тусгай хамгаалалтад авах үйл ажиллагааг аудитын түүвэрт хамруулаагүй, хязгаарласан болно.

Тус аудитаар нийт 5 байгууллагын холбогдох албан тушаалтанд 32 төрлийн зөвлөмж өгч, 8 байгууллагын холбогдох албан тушаалтанд зөрчил арилгах албан шаардлага, 1 байгууллагад төлбөрийн акт тогтоосон. Дэлгэрэнгүй байдлаар хүснэгтэд харуулав:

№	Аудитын байгууллагаас гаргасан шийдвэрийн нэр, огноо, дугаар			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан байгууллага, албан тушаалтны	
	Нэр	Огноо	Дугаар	Байгууллагын нэр	Албан тушаал
1	Албан шаардлага	2019.12.25	1/358	БОАЖЯ	Сайд
2	Төлбөрийн акт	2019.12.25	01/132	БОАЖЯ	Сайд
3	Албан шаардлага	2019.12.25	1/359	Горхи Тэрэлжийн БЦГ-ын Хамгаалалтын захиргаа	Дарга
4	Албан шаардлага	2019.12.25	1/360	Богд хан уулын ДЦГ-ын Хамгаалалтын захиргаа	Дарга
5	Албан шаардлага	2019.12.25	1/361	ХУД-ИТХ	ИТХ-ын дарга
6	Албан шаардлага	2019.12.25	1/362	ХУД	Засаг дарга
7	Албан шаардлага	2019.12.25	1/363	БЗД	Засаг дарга
8	Албан шаардлага	2019.12.25	1/364	Налайх дүүрэг	Засаг дарга
9	Албан шаардлага	2019.12.25	1/365	ГЗБГЗЗГ	Дарга
10	10-н төрлийн зөвлөмж	2019.12.25	-	Засгийн газар	Ерөнхий сайд
11	7-н төрлийн зөвлөмж	2019.12.26	-	ЗГХЭГ	Дарга
12	5-н төрлийн зөвлөмж	2019.12.27	-	БОАЖЯ	Сайд
13	4-н төрлийн зөвлөмж	2019.12.28	-	Алтанбулаг, Замын-Үүд, Цагаан нур ЧБЗ	Захирагчид
14	6-н төрлийн зөвлөмж	2019.12.28	-	ГЗБГЗЗГ	Дарга

7. Эрсдэлийн үнэлгээ:

Төлөвлөлтийн өмнөх болон төлөвлөлтийн үе шатны явцад судалсан баримт материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн ерөнхий эрсдэлийг “ИХ” гэж үнэлсэн. /Эрсдэлийн бүртгэлийн дэлгэрэнгүйг хавсралт 1¹-д үзүүлэв/

8. Арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Монгол Улсын стандарт: Төрийн аудит MNS6817:2020 болон Төрийн хяналт шалгалтын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/146 дугаар тушаалаар баталсан Нийцлийн аудитын түр журмыг баримтлан өмнөх аудитаар Үндэсний аудитын газраас акт, албан шаардлага, зөвлөмж хүргүүлсэн байгууллага, албан тушаалтнуудын холбогдох шийдвэр, үйл ажиллагаа, баримт материал, хувийн хэрэг, газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулах зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулна. /Асуудлын шинжилгээг хавсралт 2¹, арга зүйн дэлгэрэнгүйг хавсралт 3¹-д үзүүлэв/

9. Аудитад ашиглах шалгуур үзүүлэлт:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана. Үүнд:

- Авто замын тухай хууль;
- Ашигт малтмалын тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Газрын хэвллийн тухай хууль;
- Геодези, зураг зүйн тухай хууль;
- Захиргааны ерөнхий хууль;
- Зөрчлийн тухай хууль;
- Иргэний нисэхийн тухай хууль;
- Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль;
- Газрын төлбөрийн тухай хууль;
- Газрын тухай хууль;
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль;
- Иргэний хууль;
- Ойн тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Төмөр замын тээврийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Төрийн болон албаны нууцын тухай хууль;
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай;
- Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай;
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль;

¹ Тайлбар: Тухайн хавсралтыг зөвхөн Төрийн аудитын байгууллагын дотоод хэрэгцээнд ашиглана.

- Улсын бүртгэлийн ерөнхий хууль;
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль;
- Усны тухай хууль;
- Харилцаа холбооны тухай хууль;
- Чөлөөт бүсийн тухай хууль;
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль ;
- Эрчим хүчний тухай хууль;
- Үндсэн хуулийн цэцийн 1995 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн "Монгол Улсын Газрын тухай хууль болон Иргэний хуультай холбогдсон маргааныг хянан хэлэлцэн тухай дүгнэлт";
- Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 дугаар хавсралтаар баталсан журмууд;
- Засгийн газрын 2003 оны "Хураамжийн хэмжээг тогтоох тухай" 205 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолоор баталсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам";
- Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолоор баталсан "Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам";
- Засгийн газрын 2017 оны 287 дугаар тогтоолоор баталсан "Газрын улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, заагийг тогтоох, ашиглах журам";
- ГХГЗЗГ-ын даргын 2008 оны 83 дугаар тушаалаар баталсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам";
- ГХГЗЗГ-ын даргын 2009 оны 224 дүгээр тушаалаар баталсан "Газрын нэгдмэл сангийн тоо бүртгэл хөтлөх журам";
- ГХГЗЗГ-ын даргын 2010 оны 16 дугаар тушаалаар баталсан "Нэгж талбар дугаарлах журам";
- ГХГЗЗГ-ын даргын 2011 оны 171 дүгээр тушаалаар баталсан "Газрын кадастрын мэдээллийн санг ажиллуулах журам";
- "Геодезийн байнгын цэг, тэмдэгт байгуулах ажил" /БД 11-104-06/ дүрэм;
- "Хиймэл дагуул (gps/глонасс)-ын технологиор Монгол Улсын геодезийн сүлжээ байгуулах үндсэн дүрэм" БНБД 14-101-08;
- "1:500, 1: 000, 1:2 000, 1:5 000-ны масштабтай байр зүйн зураглалын ажил" /БД 11-106-08/ дүрэм;
- ГХГЗЗГ-ын даргын 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн А/112 тоот тушаалаар баталсан "2005 оны 1 дүгээр 1-ний өдрийн эрин бүхий ITRF2008 солбицлыг бүх төрлийн байр зүйн болон кадастрын хэмжил, зураглалд ашиглах тухай журам";
- ГХГЗЗГ-ын даргын 2013 оны 93 дугаар тушаалаар баталсан "Нэгж талбарын хилийн эргэлтийн цэг, тэмдэгтийн загвар";
- "Төмөр замын зурvas газарт тавих шаардлага" MNS 6060 : 2010;
- Байгаль орчин, Дэд бүтцийн хөгжил, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар баталсан "1995 оны тушаал "Хүн амын унд, ахуйн усны эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэм";
- НИТХ-ын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны 5/14 дүгээр тогтоолоор баталсан "Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх, хугацааг сунгах, газрын зориулалтыг өөрчлөх үйл ажиллагааны журам";

- Холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм журам.

10. Аудитыг гүйцэтгэх хугацаа:

Аудитын төлөвлөлтийн өмнөх үе шатны ажлыг 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс, төлөвлөлтийн үе шатны ажлыг 2019 оны 09 дүгээр сарын 14-ний өдрөөс, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2020 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс, тайлагналын үе шатны ажлыг 12 дугаар сарын 01-ний өдрөөс тус тус эхлүүлэн гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн дотор МУЕА-ын тушаалаар баталгаажуулан УИХ-д хүргүүлнэ. /Аудитын үр өгөөжийн төлөвлөлтийг хавсралт 4¹, нарийвчилсан цаглабар бүхий хөтөлбөрийг хавсралт 5²-д үзүүлэв/

11. Аудитыг гүйцэтгэх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг ЯАГ-ын НАГ-ын захирал бөгөөд тэргүүлэх аудитор С.Энхбаатар хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Отгонбаяр ахлан, аудитор С.Сугармаа, В.Орхон, Ж.Дэмчигсүрэн нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэнэ.

12. Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц:

А. Боловсон хүчин:

- ЯАГ-аас: 6 хүн* 109 өдөр = 654 хүн/өдөр.

Б. Санхүүгийн нөөц:

- Цалин – 60,954.0 мянган төгрөг;
- Төв аймгийн болон Налайх дүүргийн УТХГН-н давхардлын асуудлаар томилолтоор ажиллах зардал – 5 хүн* 2 хоног* 69.0= 690.0 мянган төгрөг;
- Техник хэрэгсэл ашиглалтын зардал -53.3 мянган төгрөг

Нийт зардал: 61,697.3 мянган төгрөг.

В. Техник хэрэгсэл: Томилолтоор ажиллах автомашин, газрын кадастрын хэмжилт хийх багаж төхөөрөмж, зөөврийн компьютер болон бусад тоног төхөөрөмж.

ТАНИЛЦСАН: МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.ТЭНГИС

ХЯНАСАН: НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЭНХБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.БОЛДБААТАР

БОЛОВСРУУЛСАН: АХЛАХ АУДИТОР

Д.ОТГОНБАЯР

АУДИТОР

С.СУГАРМАА

АУДИТОР

В.ОРХОН

АУДИТОР

Ж.ДЭМЧИГСҮРЭН

